

ӨМЧИЙН МЕНЕЖМЕНТИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН С.СЭРЖЖАРГАЛЫН
2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1	Арга хэмжээ: 2.2.2 Хувьцаа эзэмшигчдийн хурлын төлөөлөгч, ТУЗ-ийн гишүүнд нийслэлд холбогдох мэргэжлийн байгууллагаас төлөөлөл зайлшгүй оруулах	НИТХ-н тогтоолоор гишүүдийг томилох	2 тогтоол	Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох гишүүн, ТУЗ-н гишүүнийг томилох	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн 23 дугаар тогтоолоор “Хишиг-Уул” ХК-ийн нийслэлийн мэдлийн 34 хувийг төлөөлөлөх ТУЗ-ийн гишүүнээр томилогдсон бөгөөд тус компанийн ТУЗ-ын 2024 оны 3 дугаар сарын 21-ны өдрийн хуралд оролцож саналаа өгсөн. “Хишиг-Уул” ХК-ийн 2024 оны 04 сарын 01-ны өдрийн 2024.04.30-ний өдөр хуралдах хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох төлөөлөгчийг томилж нэр ирүүлэхийг хүссэн 04, 09 дугаар бүхий албан бичгүүдийн дагуу НИТХ-ын тогтоолын төсөл боловсруулан холбогдох бичиг баримтын хамт НИТХ-ын ажлын албанд 2024.04.22-ны өдрийн 2/739 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. Тус асуудлыг НИТХ-ын нам, бүлэг, хороодын хурлаар хэлэлцүүлэн НИТХ-ын 2024.04.29-ний өдрийн хурлаар хэлэлцүүлэн 64 дүгээр тогтоолоор “Хишиг-Уул” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг төлөөлж оролцох итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр НЗДТГ-ын Нийгтийн Бодлогын хэлтсийн дарга П.Хасбаатарыг томилуулсан.	2024.01.01-2024.04.30	100%
2	Арга хэмжээ: 2.5.13	Мэдээллийн сан	5 хуулийн этгээ	5 хуулийн этгээд	“Багахангай мах боловсруулах үйлдвэр” ОНӨААТҮГ, “Төв цэнгэлдэх хүрээлэн” ХК”, “Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлэг”, “Уламжлалт	2024.03.01-	100%

	Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хүлээн авч, мэдээллийн санг бүрдүүлэх	баяжигдах	даж, ахуйн нэгж	аж, ахуйн нэгж	анагаах ухаан элэг судлалын клиник төв", "Хишиг-Зүл" ХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг тулгаж хүлээн авсан.	2024.05.31	
3	Арга хэмжээ: 2.6.1 Хувьчлалын бэлтгэл ажлыг хангах, Нийслэлийн Өмч хувьчлах комиссын хурлаар холбогдох асуудлуудыг хэлэлцүүлж, шийдвэрийн хэрэгжилтийг хангах	-Хурлын тоо Хурлын шийдвэр	Тухай бүр	Өмч хувьчлах комиссын тогтоолоор хувьчлах эд хөрөнгийн үнэлгээг тогтоолох	Нийслэлийн өмч хувьчлалын жагсаалтад орсон боловч хувьчлагдаагүй барилга байгууламж, хуулийн этгээдүүдийн тухай танилцуулга, хөрөнгийн нэгдсэн хүснэгт, Power point бэлтгэн Нийслэлийн Засаг даргад танилцуулсан бөгөөд хувьчлалын жагсаалтад байгаа төрийн үйлчилгээний барилгууд, халуун усны барилгуудыг хувьчлалын жагсаалтаас хасах үүрэг өгсөн. Тус үүргийг хэрэгжүүлэх үүднээс: 1. Хувьчлалын жагсаалтад орсон боловч хувьчлагдаагүй 9 барилга байгууламжийг хувьчлалын жагсаалтаас хасах тухай НИТХ-ын тогтоолын төсөл, Power point, НЗД-ын зөвлөлийн хурлын тэмдэглэл, 11 барилгын танилцуулга, НЗД-н зөвлөлийн хурлын тэмдэглэл, өргөн барих бичиг боловсруулан НЗДТГ-ын эрх бүхий албан тушаалтнуудаас санал авсан. НӨХГ-ын 2024.01.04 -ны өдрийн 2/13 дугаар албан бичгээр СБД-ийн ЗДТГ-аас тухайн дүүргийн нутаг дэвсгэрт байрлалтай 7 барилга байгууламжийг хувьчлалын жагсаалтаас хасуулах асуудлыг НИТХ-д танилцуулахаар бэлтгэж байгаатай холбогдуулан дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар засаж сайжруулан ашиглах эсэх саналаа ирүүлэхийг мэдэгдсэн. СБД-ийн ЗДТГ-аас 2024.01.24-ны өдрийн 4/136 дугаар албан бичгээр тус барилгуудыг хувьчлалын жагсаалтаас хасуулах саналтай бөгөөд 15,16,18 дугаар хороодод байрлалтай халуун усны барилгуудыг	2024.01.01-2024.06.30	100%

				дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар засаж сайжруулан цаашид ашиглах саналаа ирүүлсэн. НӨХГ-ын 2024.01.04-ны өдрийн 2/14 дугаар албан бичгээр ХУД-ийн ЗДТГ-аас тухайн дүүргийн нутаг дэвсгэрт байрлалтай 2 барилга байгууламжийг хувьчлалын жагсаалтаас хасуулах асуудлыг НИТХ-д танилцуулахаар бэлтгэж байгаатай холбогдуулан дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар засаж сайжруулан ашиглах эсэх саналаа ирүүлэхийг мэдэгдсэн. ХУД-ийн ЗДТГ-аас 2024.01.08-ны өдрийн 03/27 дугаар албан бичгээр тус барилгуудыг хувьчлалын жагсаалтаас хасуулах саналтай бөгөөд 16 дугаар хорооны халуун усны барилгыг дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар засаж сайжруулан цаашид ашиглах саналаа ирүүлсэн. Мөн тухайн асуудлыг НЗД-ын зөвлөлийн хурал, НИТХ-ын зөвлөлийн хурал, нам бүлгүүдийн хурал, хороодын хурлаар хэлэлцүүлэн НИТХ-ын 2024.04.29-ний өдрийн хурлаар хэлэлцүүлэн 13 дугаар тогтоолоор хувьчлалын жагсаалтаас 9 барилга байгууламжийг хасуулсан. ХУД-ийн ЗДТГ, “Чандмань Налайх” ОНӨААТҮГ-т, СБД-ийн ЗДТГ-т НӨХГ-ын 2024.02.28-ний өдрийн 2/323, 2/324, 2/325 дугаар албан бичгүүдээр НИТХ-ын тогтоолыг хүргүүлж төсвийн хөрөнгө оруулалтаар хэрхэн засаж сайжруулсан талаарх мэдээллээ ирүүлэхийг мэдэгдсэн. 2. Хувьчлалын жагсаалтад орсон боловч хувьчлагдаагүй 4 барилга байгууламжийг хувьчлалын жагсаалтаас хасах тухай НИТХ-ын тогтоолын төсөл, Power point, НЗД-ын зөвлөлийн хурлын тэмдэглэл, 11 барилгын танилцуулга, НЗД-н зөвлөлийн хурлын тэмдэглэл, өргөн барих бичиг боловсруулан НЗДТГ-ын эрх бүхий албан тушаалтнуудаас санал авсан.Мөн тухайн асуудлыг НЗД-ын зөвлөлийн хурал, НИТХ-ын зөвлөлийн хурал, нам бүлгүүдийн хурал, хороодын хурлаар хэлэлцүүлэн НИТХ-ын 2024.02.08-ний өдрийн хурлаар хэлэлцүүлэн 50 дугаар тогтоолоор хувьчлалын жагсаалтаас 4 барилга байгууламжийг хасуулсан. “Төв цэнгэлдэх хүрээлэн” ХХК,		
--	--	--	--	--	--	--

				СБД-ийн ЗДТГ-т НӨХГ-ын 2024.05.17-ний өдрийн 2/97, 2/898 дугаар албан бичгүүдээр НИТХ-ын тогтоолыг хүргүүлсэн. 3. Нийслэлийн өмчөөс 2024 онд хувьчлах эд хөрөнгийн жагсаалтад оруулах санал авахаар 9 дүүргийн Засаг даргын тамгын газар, нийслэлийн агентлагууд зэрэг 33 байгууллагуудад НӨХГ-ын 2024.03.27-ний 2/534 дугаар албан бичиг явуулсан. Тус албан бичгийн хариуд Налайх дүүргийн Засаг даргын тамгын газраас 2 барилга, Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газраас 1 барилга хувьчлалын жагсаалтад оруулахаар саналаа ирүүлсэн бөгөөд бусад байгууллагууд саналгүй гэсэн албан бичгүүдийг ирүүлсэн. Нийслэлийн өмчөөс 2024 онд хувьчлах эд хөрөнгийн жагсаалт батлах тухай НИТХ-ын тогтоолын төсөл, Power point, НЗД-ын зөвлөлийн хурлын тэмдэглэл, 11 барилгын танилцуулга, НЗД-н зөвлөлийн хурлын тэмдэглэл, өргөн барих бичиг боловсруулан НЗДТГ-ын эрх бүхий албан тушаалтнуудаас санал авсан. Мөн Хот байгуулалт, хөгжлийн газарт өөрийн эзэмшил газартай хувьчлалын жагсаалтад орсон барилга байгууламжийн газрууд дээр төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах барилга байгууламжийн төлөвлөгдсөн арга хэмжээ байгаа эсэх болон цаашид тухайн газруудад хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний саналбайгаа эсэхийг тодруулахаар 2024.04.22-ны 2/738 дугаар албан бичиг хүргүүлсэн. Хот байгуулалт, хөгжлийн газраас 2024.04.26-ны өдөр тухайн барилгуудын газруудад шинээр төлөвлөгдсөн төсөл арга хэмжээ байхгүйг тухай 03/1147 дугаар бүхий албан бичгийг ирүүлсэн. Баянгол дүүргийн ЗДТГ-т 2024.04.22-ны өдрийн 2/725 дугаар албан бичгээр Баянгол дүүргийн 7 дугаар хороонд байрлах хуучнаар “Эрхэмжаргалан” өрхийн эрүүл мэндийн төв байрлаж байсан барилга, СХД-ийн ЗДТГ-т 2024.04.22-ны 2/727 дугаар албан бичгээр СХД-ийн 21 дүгээр хороонд байрлах өрхийн эмнэлгийн барилга, Чингэлтэй дүүргийн ЗДТГ-т 2024.04.22-ний өдрийн 2/726 дугаар		
--	--	--	--	--	--	--

				албан бичгээр ЧД-ийн 18 дугаар хороонд хороонд байрлах хуучнаар “Үйлс нэгтэн” өрхийн эмнэлэг байрлаж байсан барилгын газрууд дээр төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах барилга байгууламжийн батлагдсан төсөл арга хэмжээ, санал байгаа эсэх талаар тодруулга авахаар явуулсан. БГД-ийн ЗДТГ-аас 2024.04.26-ны 05/844 дугаар албан бичгээр өрхийн эрүүл мэндийн төвийн газар дээр төсөвлөгдсөн арга хэмжээ байхгүй ба дүүргийн ахмадын хөгжлийн төвийн зорилгоор ашиглаж байр ашиглахтай холбоотой зардлыг дүүргийн төсөвт тусган шийдвэрлэх саналаа ирүүлсэн. ЧД-ийн ЗДТГ-ийн 2024.04.25-ны өдрийн 3/983 дугаар албан бичгээр өрхийн эрүүл мэндийн төвийн газар дээр төсөвлөгдсөн арга хэмжээ байхгүй бөгөөд цаашид тухайн барилгын газар дээр шинээр өрхийн эмнэлэг бариулах саналтай байгаагаа ирүүлсэн. Нийслэлийн өмчөөс 2024 онд хувьчлах эд хөрөнгийн жагсаалт батлах тухай асуудлыг НЗД-ын зөвлөлийн хурал, НИТХ-ын зөвлөлийн хурал, нам бүлгүүдийн хурал, хороодын хурлаар хэлэлцүүлэн НИТХ-ын 2024.04.29-ний өдрийн хурлаар хэлэлцүүлэхээр батлуулсан. Гэвч НИТХ-ын зарим төлөөлөгчдөөс хувьчлалын жагсаалтад оруулж буй өөрсдийн дүүрэгт байрлах барилга байгууламжуудыг дүүргийн балансад шилжүүлж авч ашиглах санал гаргасан болон бусад шалтгааны улмаас тухайн асуудлыг НИТХ-аар хэлэлцүүлэхээ түдгэлзүүлсэн. 4. Уламжлалт анагаах ухаан элэг судлалын клиник төвийг Нэмэлт хөрөнгө оруулалт хийх нөхцөлтэйгээр Хатанбаатар ахлагчтай багтай байгуулсан менежментийн гэрээний талаарх танилцуулга, Богд сувилал, Эмийн үйлдвэрийн барилгын танилцуулга, Power point, гэрээний зөрчигдсөн заалтууд болон бусад холбогдох мэдээллийг бэлтгэн НЗД-ын 1 дүгээр орлогч Сайнзоригт танилцуулсан.		
--	--	--	--	--	--	--

				Нийслэлийн Засаг даргад мэдээллийг танилцуулах шаардлагын улмаас Уламжлалт анагаах ухаан элэг судлалын клиник төвийн танилцуулгыг шинэчлэн боловсруулж газрын даргад өгсөн. Тус эмнэлэгийн 2008 оноос хойш авсан төсвийн санхүүжилтийн мэдээллийг авахаар НӨХГ-ын даргын 2024.04.22-ны өдрийн 2/728, 2024.05.08-ны өдрийн 2/828 дугаар албан бичгүүдийг Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Эрүүл Мэндийн Даатгалын Ерөнхий газруудад явуулсан. НӨХГ-ын 2024.05.08-ны өдрийн 2/834 дүгээр албан бичгээр СХД-ын 15 дугаар хороо Барилгачин зочид буудлын барилгын хувьчлалтай холбоотой мэдээллийг авах хүсэлтийг Төрийн Өмчийн бодлого зохицуулалтын газарт явуулсан. НӨХГ-ын 2024.05.21-ны өдрийн 2/912 дугаар албан бичгээр СХД-ын 15 дугаар хороо Барилгачин зочид буудлын барилгын хувьчлалтай холбоотой мэдээллийг авах хүсэлтийг Архивын ерөнхий газарт явуулсан. 5. Чингэлтэй дүүргийн 5 дугаар хороо “Нарны титэм” үйлчилгээний төвийн “Ж” блокийн барилга байгууламжийн баримт бичгүүдийг он цаг дарааллаар эмхлэн, хувилж хууль хяналтын байгууллагад хүргүүлэхэд бэлтгэсэн. НӨХГ-ын 2024.03.28-ны өдрийн 2/548 дугаар албан бичгээр “Улаанбаатар радио” ХХК-ийн нэр дээр бүртгэгдсэн тус байрны үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн лавлагаа болон холбогдох архивын баримт бичгийн лавлагаа авах хүсэлтийг Нийслэлийн Улсын бүртгэлийн газарт явуулсан. 6. НӨХГ-ын 2024.04.29-ны өдрийн 2/771 дүгээр албан бичгээр Хишиг-Уул” ХК-ний Улсын бүртгэлд бүртгүүлсэн бүртгэлийн лавлагаа болон холбогдох архивын баримт бичгийн лавлагаа авах хүсэлтийг Улсын бүртгэлийн Ерөнхий газарт явуулсан. 7. НӨХГ-ын 2024.02.19-ны өдрийн 2/272 дугаар албан бичгээр “Ану сервис” ХХК-ний менежментийн гэрээгээр ажиллуулж буй 8		
--	--	--	--	---	--	--

					уурын зуухны гэрээг дүгнэх ажлын хэсгийн гишүүдийг нэр ирүүлэх хүсэлтийн Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлсэн. “Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар” ОНӨААТҮГ-ын харьяа нийслэлийн өмчит халаалтын 8 зуухыг менежментийн гэрээгээр ажиллуулж байгаа “Ану сервис” ХХК-ны гэрээний биелэлтийг дүгнэх үүрэг бүхий Ажлын хэсгийн тушаалыг төсөл боловсруулан Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/36 дугаар тушаалаар батлуулсан. Гэрээг дүгнэх ажлын хэсэг 2024.03.22, 2024.03.25-ны өдрүүдэд тус компанийн менежментийн гэрээгээр ажиллуулж буй 8 зуух бүр дээр хийсэн техник технологийн сайжруулалт, засвар тохижилтыг газар дээр нь, нэг бүрчлэн очиж нүд үзэж танилцсаны дараа менежментийн гэрээний биелэлт, санхүүгийн тайлан баланс, хийсэн засвар үйлчилгээний ажлын гүйцэтгэлтэй тулган үйл ажиллагааны талаарх санал дүгнэлтүүдийг гаргаж байна. Ажлын хэсгийн гишүүдийн санал дүгнэлт бүрэн ирж дуусахаар нэгдсэн тайланг гаргаж газрын даргад танилцуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.. 8. Нийслэлийн Засаг даргад танилцуулах шаардлагын улмаас Баганхангай дүүргийн “Мах боловсруулах үйлдвэр” ОНӨААТҮГ-ын танилцуулгыг шинэчлэн боловсруулж газрын даргад өгсөн.		
4	Арга хэмжээ: 3.1.10 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарих	Мод тарих	Мод тарих	Мод тарих	2024.05.10-ний өдөр: Налайх дүүргийн цэцэрлэгт хүрээлэнд тарих модны төлбөрийг хураалгасан	2024. 05.10	100%
5	Дэд арга хэмжээ	Олон нийтийн арга	сургалт, семинар	сургалт, семинар, олон	Авлигатай тэмцэх газраас нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдад “2023 оны Хувийн ашиг сонирхлын		

	Албан хаагчийн албан үүргээ мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилтын хүрээнд зохион байгуулсан сургалт, семинар, олон нийтийн ажилд оролцох	хэмжээнд оролцсон байх	ар, олон нийтийн ажилд оролцох	нийтийн ажилд оролцох	мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг шинэчлэн гаргах тухай” сэдэвт сургалтад 2024.01.25-ний өдрийн 09:00-10:00 цагийн хооронд цахим (zoom) хэлбэрээр оролцсон. "Жендэрийн мэдрэмжтэй харилцаа холбоо" цахим сургалтад хамрагдсан. Нийслэлийн Засаг аргын Тамгын газрын Хүний нөөцийг хөгжлийн төвөөс явуулж буй 2 сургалтад хамрагдсан: Үүнд: 1. 2024.02.20-ний өдөр: Төрийн албан хаагчийн манлайлал 2. 2024.02.21-ний өдөр: Удирдлагын зөөлөн менежмент “Хаврын их цэвэрлэгээ” нэгдсэн арга хэмжээний хүрээнд: 1. 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр буюу маргааш 13 цагт байгууллагын оффиссын гадна 50 м хүртэл орчмын талбайд 2. 2024 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр буюу энэ бямба гаргийн 10 цагт батлагдсан хуваарийн дагуу нийт албан хаагчид Баянбүрдийн тойргоос урагшаа Тусгаар тогтнолын талбайн урд үзүүр хүртэлх талбай болон Байгууллагын оффисын дотор ажлын байр, өрөө тасалгаанд тус тус их цэвэрлэгээ хийсэн.	2024.01.01-2024.06.30	100%
6	Арга хэмжээ: 3.2.3 Төсөвт төвлөрүүлэх өмч хувьчлалын орлогын төлөвлөгөөг биелүүлэх	2 тэрбум	-	Өмч хувьчлалын орлого төвлөрүүлэх	Нийслэлийн Өмч хувьчлах комиссын хурлын төлөвлөгөөг боловсруулан холбогдох танилцуулгуудыг бэлтгэн газрын даргад танилцуулсан. Мөн өмч хувьчлалын жагсаалтад байгаа барилаг байгууламж хуулийн этгээдийн мэдээллийг Нийслэлийн Засаг дарга болон НЗДТГ-ын Хууль тогтоомж, гэрээ, эрхзүйн газрын дарга Д.Амгаланд танилцуулсан. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Нийслэлийн Өмч Хувьчлах комиссын дарга Х.Нямбаатарт НӨХГ-ын 2024.05.06-ны өдрийн 2/803 албан бичгээр нийслэлийн Өмч хувьчлах комиссын хурлыг хуралдуулж өгөх хүсэлт явуулсан. 2024 оны жхний хагас жилийн байдлаар Нийслэлийн Өмч хувьчлах комиссын хурал хурлдаагүй тул өмч хувьчлалын орлогын төлөвлөгөөг биелүүлэх боломжгүй байна.	2024.01.01-2024.06.30	100% (-)

7	Дэд арга хэмжээ Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, холбогдох дүрэм, журам болон стандартыг албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж албан бичиг, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэх	Цаг хугацаандаа шийдвэрлэх	Албан бичиг, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэх	Албан бичиг, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэх	Өргөдөл: 2024 оны эхний хагас жилд 5 өргөдөл ирсэн бөгөөд хуулийн хугацаанд нь хариуг албан ёсоор өгсөн болно. Үүнд: Иргэн С.Мягмарсүрэн, С.Пүрэвжав нараас НИТХ-ын дарга, Нийслэлийн Засаг Даргад болон Нийслэлийн Үйлчилгээний Нэгдсэн Төвөөр дамжиж манай газарт ирүүлсэн 3 өргөдөлд Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2024.05.17-ны 2/892, 2/894 дүгээр албан бичгүүдээр хариуг иргэнд биечлэн өгсөн. Иргэн Я. Нэргүйгээс Нийслэлийн Засаг даргад хандсан уулзалтын тов олгож өгөхийг хүссэн 1 өргөдлийг 2024.05.06-ны хүлээн авч холбогдох эрх бүхий албан тушаалтнуудад танилцуулан 2024.05.22-ны өдрийн 11 цаг 32 минутад гүйцэтгэх захирал Нэргүйтэй утсаар холбогдож тухайн асуудлыг хууль хяналтын байгууллагаар шалгагдаж дуусч дүгнэлт гартал уулзах боломжгүй талаар мэдэгдсэн. Иргэн Ж.Дамчаагаас 2024.06.03-ны өдөр ирүүлсэн өргөдлийг судлаж байгаа бөгөөд хуулийн хугацаанд нь хариуг хүргүүлэх болно. Ирсэн албан бичиг: 2024 оны эхний хагас жилийн байдлаар албан хэрэг хөтлөлтийн “eDoc” системээр иргэн, хуулийн этгээдээс нийт 64 албан бичиг ирсэн бөгөөд 63 албан бичгийг 100% шийдвэрлэж 1 бичиг судлаж байна. Явуулсан албан бичиг: 2024 оны эхний хагас жилийн байдлаар 69 албан бичиг боловсруулан албан хэрэг хөтлөлтийн “eDoc” системээр иргэн, хуулийн этгээдэд хүргүүлсэн.	2024.01.01-2024.06.30	100%
---	--	----------------------------	--	--	---	-----------------------	------

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ӨМ-ИЙН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН
(Албан тушаал)

.....
/С.СЭРЖОЛЖАЛ/
(Нэр, гарын үсэг)

2024.06.05
(Огноо)